



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/589

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дугаар зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 8/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд хотын Шинэ хороолол байгуулах 245 га газраас, 1 га газрыг ажилчдын орон сууц, албан хэрэгцээний зориулалтаар “Дөргөн, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөлд /9922431/ 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан төсөвт байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

3. Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга /З.Өмиртэй/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/589 Ch
02 02931